



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

Г Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТӨГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 1,950,616,146.00 (нэг тэрбум есөн зуун тавин сая зургаан зуун арван зургаан мянга нэг зуун дөчин зургаа) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Архангай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргaa, зориулалтыг харгалzan хөрөнгийг хүлээлцэх, Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын хөрөнгөд бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т урэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
21-t huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын 26-ны үдээний өдрийн
дугаар тогтолцооны хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРВСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгээрх хөрөнгийн дун (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Эрүүл мэндийн төвийн барилга (Архангай аймаг, Цахир сум, Эмнэлгийн барилга, өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төвөгшилтэй ангилалын, зорьлыг, 2 давхар, тэнхлэгээрээ 33.0m*12.4M, 10 ортоой барилга, (моргын барилга, уурьн зуухын барилга, гучийн худаг, цооног, нийтийн эзэмшил)	1,950,616,146.00	2023.11.29	ББАОКД-2023/60	Архангай аймаг, Цахир сум дахь Эрүүл мэндийн төв
			1,950,616,146.00 (нэг тэрбум есөн зуун тавин сая зураган зуун арван зураган мянга нэг зуун дөчин зураган төгрөг)			
		НИЙТ ДҮН				